



“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Компанийн оноосон нэр:

“Монгол шуудан” ХК, Сүхбаатарын талбай 1,
Энхтайвны өргөн чөлөө, ЧД 1 дүгээр хороо, Улаанбаатар 15160

Хурал хуралдуулах газар, өдөр, цаг:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 10:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхимд /Төв шуудангийн баруун хаалга, “Монгол шуудан” ХК-ийн 4 давхарт/

Хуралд оролцох эрхтэй ХЭ-чдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:

2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
 - ✓ Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах,
 - ✓ Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах,
 - ✓ Компанийн 2022 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах,
 - ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны тайлан танилцуулах,
- “Монгол шуудан” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай,
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсөв батлах тухай,

Холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас (www.mse.mn/mn/company/541), компанийн цахим хуудас (www.mongolpost.mn) дахь “Хувьцаа эзэмшигч” цэсээс электрон хэлбэрээр болон ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд өөрийн харилцаж буй брокер дилерийн компани болон компанийн төв байранд ирж авч болно.
- Хувьцаа эзэмшигч та саналаа урьдчилан өгөх боломжтой бөгөөд өөрийн үйлчлүүлдэг Үнэт цаасны компаниар дамжуулж компанид ирүүлж болно. Мөн компанийн цахим хуудас (www.mongolpost.mn) дахь “Хувьцаа эзэмшигч” цэсэд байрлах саналын хуудсыг татан авч саналаа бөглөн дараах хаягаар битүүмжлэн ирүүлж болно. Саналын хуудсаар санал авах сүүлийн хугацаа 2024 оны 04 сарын 24-ний өдрийн 17:00 цаг байна.

Хаяг: Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисст
“Монгол шуудан” ХК, Сүхбаатарын талбай-1,
ЧД-ийн 1-р хороо, Улаанбаатар 15160

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комисс: Б.Цэнд-Аюуш, Э.Солонго, Утас: 70078906

tsetsgee@mongolpost.mn, tsetsgee@mongolpost.mn

Хурлын ирцийн бүртгэл 2024 оны 04 сарын 29-ны өдрийн 09:30-10:00 цагийн хооронд явагдана.